

САНГИЙН САЙД, ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН  
ХАМТАРСАН ТУШААЛ

2018 оны 04 сарын 04 өдөр

Дугаар 66 / А/С

Улаанбаатар хот

Хамгаалалтын төлбөрийн хэмжээг  
тогтоох тухай

Дотоодын цэргийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 4 дүгээр зүйлийг үндэслэн ТУШААХ нь:

1. "Их хэмжээний үнэт зүйл, мөнгөн тэмдэгт, цацраг идэвхт үүсгүүр, химийн хорт бодис, эсхүл хүний амь нас, эрүүл мэнд, байгаль экологийн тэнцвэрт байдалд шууд хохирол учруулах эрсдэлтэй болон гэмт халдлагад өртөж болзошгүй бусад объектыг түр хугацаагаар болон зорчигч, ачаа тээшийг тээврийн замд харгалзан хүргэх хамгаалалтын төлбөрийн хэмжээ"-г хавсралтаар баталсугай.

2. Энэ тушаалыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллахыг Цагдаагийн ерөнхий газрын дарга, Дотоодын цэргийн командлагч /С.Баатаржав/, цагдаагийн байгууллагын жил бүрийн төсөвт орлого, зарлагыг тусгаж байхыг Хууль зүй, дотоод хэргийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс /Н.Цэвэлмаа/, Сангийн яамны Төсвийн бодлогын газар /Ж.Ганбат/-т тус тус даалгасугай.



Сангийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан 2018 оны 04 дугаар сарын 04-ны өдрийн 66... 17/18 дугаар тушаалын хавсралт

ХАМГААЛАЛТЫН ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ

/Нэг өдрөөр/

№	Зардлын төрөл	Мөнгөн дүн /төг/
А.Их хэмжээний үнэт зүйл, мөнгөн тэмдэгт, цацраг идэвхт үүсгүүр, химийн хорт бодис, хүний амь нас, эрүүл мэнд, байгаль экологийн тэнцвэрт байдалд шууд хохирол учруулах эрсдэлтэй, гэмт халдлагад өртөж болзошгүй объектыг түр хугацаагаар хамгаалах;		
1	Цалин	70.000
2	Шатахууны зардал	15.000
3	Бичиг хэрэг, холбоо, сургалтын зардал	5.000
4	Нийт дүн	90.000
Б.Их хэмжээний үнэт зүйл, мөнгөн тэмдэгт, цацраг идэвхт үүсгүүр, химийн хорт бодис, хүний амь нас, эрүүл мэнд, байгаль экологийн тэнцвэрт байдалд шууд хохирол учруулах эрсдэлтэй, гэмт халдлагад өртөж болзошгүй зорчигч, ачаа тээшийг тээврийн замд харгалзан хүргэх:		
1	Цалин	70.000
2	Шатахууны зардал	30.000
3	Бичиг хэрэг, холбоо, сургалтын зардал	10.000
4	Нийт дүн	110.000

Жич: Хамгаалалтын үйл ажиллагаанд үүрэг гүйцэтгэх алба хаагчид нэг өдрийн хоолны зардал 25.000 /хорин таван мянга/ төгрөг, холбооны зардал 5.000 /таван мянга/ төгрөг, зам, хоногийн зардалд 10.000 /арван мянга/ төгрөг, нийт 40.000 /дөчин мянга/ төгрөгийг хамгаалуулагч тал олгоно.

---ооо---